



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 02 өдөр

Дугаар А/204

Булган сум

“Сэтгүүлчид ба мал аж ахуй, байгаль орчин” зөвлөгөөнийг зохион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Засгийн газрын 2023 оны 62 дугаар “Өвөлжилт, хаваржилтын байдал хүндэрсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал хүндэрснээс шалтгаалж, малчдын амьжиргаа доройтож, малгүй болох, төв суурин газарт шилжих, ажилгүйчүүдийн тоо нэмэгдэх зэрэг сөрөг нөлөөлөл бий болох нөхцөл үүссэн тул хариу арга хэмжээ авах, сайн туршлагыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээх замаар малчдад мэдлэг мэдээлэл олгох “Сэтгүүлчид ба мал аж ахуй, байгаль орчин” зөвлөгөөнийг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Жаргалсайхан (Аймгийн Засаг даргын орлогч дарга)

Гишүүд: Г.Давааням (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын
хэлтсийн дарга)

Д.Батцогт (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)

Г.Алтанцэцэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албаны
дарга)

Б.Хулан (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн
захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн)

Ж.Халиунаа (Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Хэвлэлийн төлөөлөгч)

Ч.Амгалан (Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)

Г.Одсүрэн (Мал эмнэлгийн газрын дарга)

А.Гантөмөр (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын
дарга)

С.Жаргалсайхан (Ус цаг уур, орчны шинжилгээний
төвийн дарга)

Б.Мөнхбаатар (“Сайхан монгол” ТВ-ийн захирал)

Сумын Засаг дарга нар
Нарийн бичгийн дарга: Э.Уянга (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын
хэлтсийн мэргэжилтэн)

2.Зөвлөгөөнийг зохион байгуулах удирдамж, төлөвлөгөөг батлуулж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Жаргалсайхан)-д даалгасугай.

3.Удирдамжид туссан албан хаагчид, малчдыг зөвлөгөөнд зохион байгуулалттай хамруулахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ